

Монгол нутаг дахь XIII-XIV зууны үеийн хүн чулуун хөрөгт тахилын байгууламжийн судалгааны зарим асуудалд

Батдэлгэрийн Амгаланбат^{1*}, Төмөр-Очирын Идэрхангай²

Товч агуулга: Бид энэхүү өгүүллээр Монгол улсын нутаг дэвсгэрээс нэмэлтээр бүртгэсэн ерөнхий дүрслэл бүхий хүн чулуун хөргүүдийг XIII-XIV зууны үед холбогдохыг тодорхойлж нэгдсэн тархалтыг гарган эртний Монголын овог аймгийн газарзүйн байдалтай харгуулахын зэрэгцээ хүн чулуун хөргийн дүрслэл, хийц загвар, тахилын байгууламжийг археологийн малтлага судалгаа болон түүхийн сурвалжтай холбож хамрах үе, он цагийн тал дээр өөрсдийн саналыг дэвшүүлэхийг оролдсон болно.

Түлхүүр үг: Дорнод Монгол, хүн чулуун хөрөг, тахилын байгууламж, тархалт, археологийн малтлага, түүхэн сурвалж, хамрах үе

Удиртгал

Өнөөгийн Монгол улсын нутгаас түүхэн олон үед холбогдох хүн чулуун хөшөөд илрэн олдож судлагдаад байгаа нь тухайн үеийн нүүдэлчдийн эдийн болон урлаг соёл, шашин шүтлэг, зан үйлийг нэхэн тодруулах боломжийг бүрдүүлж өгдөг хөдөлшгүй түүхийн эх сурвалж болдог билээ. Түүнчлэн манай оронд хүрэл зэвсгийн үеэс эхлэн Түрэг, Уйгур, Хятан, Монгол зэрэг 5 үед хамаарах 785 (Монгол үеийн хүн чулуу, 2016: 240) хүн чулуун хөшөө илэрч судлагдаад байна. Тэдгээрээс Дорнод Монгол болон ӨМӨЗО-ны бүс нутагт төвлөн тархсан XIII-XIV зууны үед хамаарах хүн чулуун хөргийн судалгааг 1927 онд Зөвлөлтийн судлаач В.А.Казакевич эхлүүлэн (1930:1-20), 1961-1962 онд археологич Н.Сэр-оджав (1970: 79), 1969 онд Л.Л.Викторова (Баяр 2013: 81), 1967 онд “Дэлхий дахины түүх” (Баяр 2002: 33), 1979 онд С.Г.Кляшторный, С.Харжаубай, 1981-2002 онуудад археологич Д.Баяр (Баяр 2002: 37-39), 2011 онд археологич Д.Эрдэнэбаатар нар (Эрдэнэбаатар нар 2011: 227-233), 2012 онд археологич Г.Лхүндэв, Ц.Болорбат нар (Лхүндэв нар 2012: 291-297), 2013 онд археологич Г.Цэрэнбямба (2013: 84-87), 2014 онд археологич Г.Анхсанаа (2015: 158-164), 2014 онд археологич Ч.Амартүвшин нар (Амартүвшин нар, 2014), 2015 онд түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллого (Соёлын өвийн үндэсний төв, 2015), 2015 онд археологич Г.Анхсанаа (2016: 17-20), 2018 онд археологич Б.Амгаланбат (2018), 2018 онд түүхч С.Өлзийбаяр (Өлзийбаяр нар, 2019: 227-228), 2019 онд зураач Д.Амараа (2021: 90), 2022 (Идэрхангай нар, 2022), 2023 (Идэрхангай нар, 2023) онуудад археологич Т.Идэрхангай, Б.Амгаланбат, 2023 онд

археологич Г.Батболд (Батболд нар, 2023) нар тус тус бүртгэл баримтжуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн байна. 2023 оны байдлаар Монгол улсын нутагт дэвсгэрт XIII-XIV зууны үед хамаарах 123 хүн чулуун хөрөг бүртгэгдээд байна (Зураг 1).

Дорнод Монголын бүс нутгаас нэмэлтээр бүртгэсэн хүн чулуун хөрөгт тахилын байгууламж: Дорнод Монголын бүс нутгаас сүүлийн жилүүдэд олон тооны хүн чулуун хөрөг шинээр бүртгэгдсэн нь тухайн дурсгалын судалгаа улам өргөжөн тэлж буйг харуулна.

Бид 2022 онд “Чулуун соёлын өв” хөтөлбөрийн нэг хэсэг болох Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн нутагт орших чулуун дурсгалыг бүртгэх ажлын хүрээнд Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Хөргийн хөндий-01, Хавх толгой, Сэнж уул, Буян-Өндөр, Зүүн нүхт, Сайхан хөндийн зүүн дээр, Сайхан хөндийн баруун хяр, Бургастайн хөндийн хойд энгэр, Сэнжийн баруун энгэр, Хадтай сэрүүн, Хонгорын овоо, Зүүн булаг зэрэг газраас 32 хүн чулуун хөрөгт тахилын байгууламжийг тус тус давтан (Амараа 2021: 90) бүртгэсэн (Идэрхангай нар, 2022: 1-200) (Зураг 2) билээ.

Мөн 2023 онд хайгуул судалгааны ажлын хүрээнд Дорноговь аймгийн Иххэт сумын Хар овоот, Ширээгийн голын Хар дэл, Ширээгийн голын тал, Даргиатын гол хэмээх газруудаас 6 хүн чулуун хөрөгт тахилын байгууламжийг шинээр бүртгэсэн билээ (Зураг 3).

Ийнхүү 2022-2024 онд нийт 38 хүн чулуун хөргийн бүртгэн баримтжуулалтын ажлыг хийж 2002 оны 69 (Баяр 2002: 1-120), 2014 оны 78 (Амартүвшин нар, 2014), 2019 оны 83 (Амгаланбат 2019: 1-114) хүн чулуудын бүртгэлийг 2023 оны байдлаар 123-т хүргээд байна. Энэ тоо баримт цаашид нэмэгдэх бүрэн боломжтой бөгөөд бидний энэ удаагийн судалгаанд ӨМӨЗО-ны нутагт орших 20 орчим хүн чулуун хөрөг, Хэнтий аймгийн нутагт орших Цувраа уул, Хүрэн

¹ Соёлын Өвийн Үндэсний Төв

² МУИС, Шинжлэх Ухааны Сургууль, Антропологи, Археологийн тэнхим, Нүүдэлчдийн археологийн хүрээлэн

* Холбоо барих зохиогч: amgalanbatbatdelger@gmail.com

чулуут зэрэг газарт орших бүлэг хүн чулуун хөргийг хамруулаагүй болно. 2023 онд Монголын XIII-XIV зууны үед хамрах боломжтой хүн чулуун хөргийн судалгаанд нэмж бүртгэгдсэн 38 хүн чулуун хөргийн дүрслэл болон тахилын байгууламжийг яагаад чухам энэ үед холбон авч үзсэн талаар өгүүлэх нь зүйтэй болов уу.

Бидний давтан болон шинээр илрүүлэн бүртгэсэн 38 хүн чулуун хөргүүд дотор Зүүнбулаг болон Ширээгийн голын хүн чулуун хөргүүд нь баруун гартаа суурь бүхий хундага барьж, зүүн гараа өвдөг дээрээ авч, тавцан сандал дээр суусан зэрэг нь өмнөх судлаачдын үзсэн XIII-XIV зууны үеийн хүн чулуун хөрөгтэй дүрслэлийн хувьд адил төстэй байх нь тухайн үеийн хүн чулууд болохыг илтгэх ажээ. Харин 36 хүн чулуун хөрөг нь дүрслэл болон арга барилын хувьд ерөнхий байдалтай хүний нүүрний дүрслэл, толгойн дүрслэл, гар, хундага, хөл зэргийг хийсвэр байдлаар болхи дүрсэлсэн нь хүн чулуун хөргүүдийн хамрах үеийг тодорхойлоход төвөгтэй болж байна. Гэсэн хэдий ч бид тухайн хүн чулуун хөргүүд өмнөх судлаачдын тодорхойлсон XIII-XIV зууны үеийн хүн чулуун хөргүүдтэй газарзүйн байршлын хувьд нэг бүс нутагт бүлэглэн оршиж байгаа, тахилын байгууламжийн гадаад зохион байгуулалт нь адилхан, мөн Түрэгийн үед хамаарах ерөнхий дүрслэл бүхий тахилын онгоноос өөр (Зураг 4) зэрэгт үндэслэн XIII-XIV зууны үед хамаарах боломжтойг тодорхойлсон ба цаашид малтлага судалгааны ажлыг хийхээр төлөвлөж байна.

Хүн чулуун хөргийн тархалтыг эртний түүхэн газарзүйтэй харьцуулах нь: XIII-XIV зууны үед хамруулан үзэж байгаа хүн чулуун хөргүүдийн тархалтыг нэгтгэн авч үзвэл, өнөөгийн Монгол улсын нутагт 123, ӨМӨЗО-ны нутагт бидний үзсэн 11 нийт 134 хүн чулуун хөрөг одоогоор бүртгэл судалгаанд хамрагдсан байна. Тухайн хүн чулуун хөргүүдийн нэгдсэн тархалт Дорнод Монголын тал нутгаас эхлэн Хэнтий, Хангайн нурууны салбар уулсаар дамжин Монгол Алтайн салбар уулс хүрсэн (Зураг 5) хэдий ч тархалтын төвлөрөл нь Хэнтийн уулсаас эртний Юань улсын дээд нийслэл Шанд хот хүртэл зурвас нутгаар тэр дундаа, Дорнод Монголын бүс буюу Сүхбаатар аймгийн Онгон, Дарьганга, Эрдэнэцагаан сумдын нутгаар нэг газар олон тоогоор бүлэглэн тархсан байдаг нь (Зураг 6) ихэд сонирхолтой байна. Түүнчлэн Дорнод Монголд төвлөн тархсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг төрөл зүйлээр ангилан авч үзвэл Тамсаг булаг, Устай бургастай зэрэг чулуун зэвсгийн үеийн томоохон сууринаас эхлэн дөрвөлжин булшны соёл, улаан зуухын соёл, шоргоолжин булшны соёлын дурсгалууд голлон тархсан нь XIII-XIV зууны үеийн хүн чулуун хөргийн тархалтай нэг бүс нутагт оршино. Мөн XIII-XIV зууны үеийн хүн чулуун хөргийн

тархалтыг өмнөх үеийн томоохон дурсгалуудын тархалтай холбон авч үзэх нь тухайн дурсгалын угсаа гарвал, үүсэл хөгжлийг тодруулахад сэжүүр болох магадлалтай. Иймд бид Монголын зүүн бүс нутагт төвлөн тархсан хүрлийн үеийн дөрвөлжин булш, хадны зураг болон Хамаг Монголын овог аймгуудын газар нутгийн тархалтай харьцуулан үзсэн билээ. Монголын зүүн бүсийн эртний томоохон соёлын нэг бол дөрвөлжин хашлага, тахилын зурагт хавтан чулуу, хүн чулуу, хөшөө чулуу зэргээс бүрдсэн дөрвөлжин булшны соёл юм. Тухайн дурсгал нь сүүлийн үеийн судалгаагаар Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрээс эхлэн Монголын төв болон баруун аймгийн нутагт тархсан бөгөөд 15991 орчим дөрвөлжин булш бүртгэгдсэн байна (Хүслэн 2023: 1-130) (Зураг 7). Мөн дараагийн нэгэн сонирхолтой дурсгал Дорнод Монголын бүс нутаг болон говийн бүс нутгаар тархсан хүний нүүрний дүрслэл бүхий хадны зураг билээ. Энэхүү дурсгалыг судлаачид шинэ чулуун зэвсгийн үеэс эхлэн дүрсэлсэн хэмээн үздэг бөгөөд Монгол улсын говийн бүс нутаг болон БНХАУ-ын ӨМӨЗО-ны бүс нутгаар голчлон тархсан байдаг хэмээн үзжээ (Амартүвшин нар, 2020: 7-38) (Зураг 8). Эдгээр дурсгалын тархалтаас бидний судлан буй XIII-XIV үед хамаарах хүн чулуун хөргүүдтэй хамгийн ойр судалгаа бол Хамаг Монголын түүхэн газарзүйтэй харьцуулах судалгаа билээ. Түүнчлэн судлаачдын бүтээлүүдээс үзэхэд өнөөгийн Дорнод Монголын бүс нутагт эртний Хонгирад, Онгууд овог аймгууд төвлөж сууж байсан мэдээлэл байна. Тухайлбал, Рашид ад-Дины “Судрын чуулган” хэмээх бүтээлд Хонгирад овог аймаг Монгол, Хятадын хооронд үргэлжилсэн Уткүх хэрмийн арын Утажиэ гэдэг газар юм хэмээн өгүүлсэн байна (Рашид ад-Дин 2002: 116-119). Монголын түүхийн таван боть бүтээлд “... тэд XII зууны эхэнд Цагаан хэрмээс хойш нутаглаж байсан ба XII зууны 2-р хагаст буюу 1170-1200 онд Халх голоор нутаглаж байсан” хэмээн өгүүлжээ (Монгол улсын түүх, 2003: 70-71). Хонгирадын ойр төрлийн Олхунуд, Ихирэс, Харануд, Хонхлиуд (Кункилулут-Ж.Г) нар Хянганы нурууны баруун урдуур, цагаан хэрмээс хойш нутаглаж байжээ (Гэрэлбадрах 2002: 67) хэмээн дурдсан байна. Түүхийн сурвалжийн ихэнх бүтээлүүдээс үзэхэд Хамаг Монголын үед Монголын зүүн хэсэгт Хонгирад, Олхонууд, Татар зэрэг аймгууд оршин байсан нь хүн чулуун хөргүүдийн бүс нутагтай давхцаж байна (Зураг 9).

Хүн чулуун хөрөгт тахилын байгууламжийн малтлага судалгаа: Монгол нутагт орших XIII-XIV зууны үед хамаарах хүн чулуун хөрөг тус бүр ардаа тахилын байгууламжтай байдаг нь нийтлэг бөгөөд гагцхүү чулуун хөргийн дүрслэл ур хийцээс хамаарч хэмжээ нь том жижиг байдаг. Тухайн чулуун хөргүүд ихэнх тохиолдолд тахилын байгууламжийн гол хэсэгт

урагш харан байрлаж буй нь Түрэг болон бусад үеийн хүн чулуудаас онцлог байдаг. Хүн чулуун хөрөгт тахилын байгууламжийн малтлага судалгааг анх 1962 онд археологич Н.Сэр-Оджав Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Өлзийт хэмээх газарт хийж нэг нүцгэн хүн чулуун хөрөг илрүүлсэн байна. Үүний дараа 1982-1985 онд археологич Д.Баяр тэргүүтэй судлаачид Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Ламт, Хөргийн хөндий, Гөхөл, Онгон сумын Шивээт зэрэг газруудад 9 дурсгалыг малтан судалж оршуулгын дурсгал бус тахилын дурсгал гэж тодорхойлсон байна. 2017 онд академич С.Чулуун нар Төв аймгийн Баянцагаан сумын нутаг Хүүхэн хонгор хэмээх газарт байрлах Монголын үеийн 2 хүн чулуун хөрөгт тахилын байгууламж дээр авран хамгаалах малтлага судалгаа хийж гарсан олдвор хэрэглэгдэхүүнээс үндэслэн XVII зууны үе хүртэл тахилга үйлдэж байсныг тогтоожээ (Чулуун нар, 2018: 246-250). 2018 онд С.Өлзийбаяр нар Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутагт орших Хөргийн хөндийн тахилын байгууламжийг малтан судалж ваарны хагархай болон бусад жижиг олдвор хэрэглэгдэхүүнийг илрүүлэн олж (Өлзийбаяр нар, 2019: 227-228) шинжилгээ хийсэн нь дээжийн урьдчилсан үр дүнгээр XIII-XIV зууны үе хэмээн гарсан байна. Энэхүү хүн чулуун хөрөгт тахилын байгууламж дээр хийсэн малтлага судалгаануудаас үзэхэд олдвор хэрэглэгдэхүүнд тулгуурласан он цаг харилцан адилгүй гарсан нь XIII-XIV зууны үеийн хүн чулуун хөргүүдийн он цагийг тодорхойлох багтай баримт болж өгсөн зүйл үгүй аж. Харин XVII зууны үе хүртэл тухайн хүн чулуун хөрөгт тахилын байгууламж дээр тахилгыг тасралтгүй хийж ирсэн нь Хүүхэн хонгор хэмээх дурсгалын малтлага судалгаанаас тодорхой болж байна.

Хүн чулуун хөрөгт тахилын байгууламжийн ойролцоо орших монгол булшны малтлага судалгаа: Бидний судалж буй хүн чулуун хөрөгт тахилын байгууламж эртний тахилын газар болох нь тархалт, нэг газарт бөөнөөрөө байгаа, тахилын байгууламжаас тахилын зүйлс гардаг зэргээс тодорхой болсон билээ. Тухайн тахилын газрын ойр орчимд монгол булш цөөн тоотой илэрч олдсон бөгөөд түүний томоохон төлөөлөл нь Сүхбаатар аймгийн Онгон сумын Таван толгой хэмээх газарт байрлах уран нарийн хийц бүхий хүн чулуун хөрөгт тахилын байгууламжийн баруун урд орших монголын үеийн язгууртны оршуулгын дурсгалт газар билээ. Энэхүү газрын хүн чулуун хөрөгт тахилын байгууламжийг 1927 онд Зөвлөлтийн судлаач В.А.Казакевич анх илрүүлэн 1981 онд археологич Д.Баяр давтан судалсан бол булш оршуулгын дурсгалыг 2000-2004 онуудад археологич Д.Наваан (2006: 10-28), 2021 онд антропологич М.Эрдэнэ нар (2021: 97), 2010, 2022 онд археологич Ц.Төрбат нар (2017: 218-226; 2022: 220-223) тус тус малтан судалж

олон тооны сонирхолтой эд өлгийн зүйлийг илрүүлэн он цагийг тогтоох судалгааг хийж XIII-XIV зууны үе буюу Юань улсын үед хамаарах алтан ургийн язгууртны дурсгал хэмээн тодорхойлсон байна. Энэхүү дурсгалт газар нь Монгол улсын хэмжээнд одоогоор ганцхан илэрч олдсон нь онцлог бөгөөд тухайн тахилга тайлга булш оршуулгын дурсгалыг чухам хэнд зориулан үйлдсэн тухай асуулт гарч ирж байна. Мэдээж уран нарийн дүрслэл бүхий хүн чулуун хөрөгт том хэмжээний тахилын байгууламжтай, эргэн тойрон олон тооны монгол булштай зэргээс үзэхэд зэрэг дэв өндөр, хаад язгууртанд зориулан үйлдсэн нь тодорхой байна. Сүхбаатар аймгийн Онгон сумын Таван толгой хэмээх газраас гадна хүн чулуун хөрөгт тахилын байгууламжийн орчимд Монгол булш байх магадлалтай дурсгал цөөнгүй байх хэдий ч тэдгээрийг зөвхөн малтлага судалгаагаар тодорхойлж болно. Үүний нэг жишээ нь Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутагт орших 1981-1982 онд археологич Д.Баяр илрүүлэн судалсан Ламтын хүн чулуун хөрөгт тахилын байгууламжийн зүүн урд талд байрлах Ламт уулын баруун урд бэлээр Монгол булш байрлах ажээ. Энэ бүхнээс үзэхэд хүн чулуун хөрөгт тахилын байгууламжийн ойр орчимд буюу тухайн тахилын газарт дагуул байдлаар оршуулсан булш оршуулгын дурсгалууд байрлах боломжтой хэмээн үзэж байна.

Түүхэн сурвалжийн мэдээ: Монголын XIII-XIV зууны үеийн судалгааны нэгэн томоохон хэрэглэгдэхүүн бол “Монголын нууц товчоо”, “Юань улсын судар”, “Монголчуудын түүх”, “Дорно этгээдэд зорчсон минь” зэрэг эртний сурвалж бичгүүд байдаг. Эдгээрээс бидний өгүүлэн буй хүн чулуун хөргүүд болон тахилга тайлгын холбоотой мэдээллийг шүүн үзвэл, Монголын нууц товчоонд “...Амбагай хааны хоёр хатан Орбай, Сохотай нар өмнө тогтсон заншил ёсоор идээ цагааныхаа дээжийг ихсийн газарт өргөх...” (Бира нар, 2009: 97-98) хэмээн гардаг. Гильом де Рубрукын Дорно этгээдэд зорчсон минь хэмээх түүхэн тэмдэглэлийн аравдугаар бүлэгт “...Язгууртныг оршуулсан газрын хавь нутагт булшийг сахих хүмүүс суух байр бий. Команууд бунхны дэргэд том шороо овоолж үхсэн хүндээ дурсгал болгон хүйсний тус газар гартаа аяга барьсан хүн чулуу зүүн тийш харуулан зогсооно” хэмээн өгүүлсэн байдаг. Мөн Юань улсын судар түүхэнд тэмдэглэлд тахил тайлгын талаар “... Ю Тай Фү Тай пин вангийн хамт дээдсийн чулуун хөргийг тахисан нь Луан жү-гээс баруун хойш далан газрын зайтай Шу ни бай гэдэг газар тавцанд байгуулсан жижиг гэрт архиар тахин аманд нь түрхэн биеийг нь өөх тосоор мялаах ёсон бий, Хубилай хаан Жүн Түгийн 2-р онд [1261] өөрийн биеэр умарш дайлах үедээ зуны 4-р сард хөхөгчин гахай өдөр Хэн Жүгийн баруун талд мөргөл үйлдэж айргаар цацал цацаж дээдэстэй өргөдөг ба энд зөвхөн

хааны угсааны хүмүүс оролцсон” (Юань улсын судар, 188-р боть) хэмээжээ. Энэхүү түүхэн сурвалжуудад дурдагдсан мэдээллүүдээс үзэхэд Юань улсын түүхэн сурвалжид хүн чулуун хөрөг тахих болон тахилга үйлддэг байсан талаар тодорхой өгүүлэгдэж байгаа нь сонирхолтой байна.

Судалгааны хэлэлцүүлэг

XIII-XIV зууны үеийн хүн чулуун хөргүүдийн тархалтын нэгдсэн байдлаас харахад Дорнод Монголын бүс нутагт төвлөн тархсан нь ихэд сонирхолтой бөгөөд эдгээр хүн чулуун хөргүүд нь Чингис хааны алтан ургийнхтай хамааралтай гэж үзвэл тэдний анх мандан гарсан Хэнтий нурууны Бурхан Халдун уулын ойр орчим болон Монголын эртний нийслэл Хархорум хотын ойр төвлөн тархаагүй вэ гэдэг асуулт урган гарч байна. Энэхүү асуултын хариултад хамгийн ойрхон хувилбар бол нэгдүгээрт Чингис хааны алтан ургийн хаад язгууртны төвлөсөн тахилын газар байсан, хоёрдугаарт Алтан ургийн хаад язгууртны хэлхээ холбоо бүхий овог аймгийн дурсгал, гуравдугаарт Юань улсын их хаан Хубилайн Их Монгол улсын нийслэлийг Шандунд шилжүүлсэнтэй холбоотой тэр бүс нутагт тахилга үйлддэг болсон зэрэг болно. Дээрх хувилбаруудаас бид Дорнод Монголын нутагт оршин сууж байсан алтан ургийн хаад язгууртнуудтай хэлхээ холбоотой язгууртнуудын үлдээсэн дурсгал буюу төвлөрсөн тахилын газар байсан байж болох талтай хэмээн үзэж байна.

Хүн чулуун хөргүүдийн тархалтаас үндэслэн үзэхэд Хонгирад, Татар, Олхонууд зэрэг овог аймгийн бүс нутагтай давхцаж буй нь сонирхолтой байна. Тухайн овог аймгуудын түүхийг нягтлан үзвэл, Дорнод Монголын нутагт Хонгирад, Олхонууд, Ирхис зэрэг овгууд эрт дээр үеэс нутаглан төвлөн сууж, урт удаан жил амьдарсан байх ба Хонгирад овог аймгаас олон хатад, баатар эрс төрөн гарсан байдаг. Энэхүү хүн чулуун хөргийн тархалтаас угсаа гарвал үүсэл хөгжлийг тодруулах анхан шатны судалгааны үр дүнд Монгол угсаа гарвал бүхий овог аймгийн дурсгал байх боломжтой хэмээх урьдчилсан саналыг дэвшүүлж байна. Бид бүхэн судалж буй сэдвийн хүрээнд шинжлэх ухааны үндэслэл бүхий нотлох баримтыг баримтлан өөрсдийн саналыг дэвшүүлэх нь судалгааг улам өргөжүүлэн тэлэхийг зорьсон болно. Нэмж өгүүлэхэд XIII-XIV зууны үеийн хүн чулуун хөргийг тухайн үеийн хаад язгууртны тахилга тайлгад зориулан үйлдсэн нь тодорхой бөгөөд харин ерөнхий дүрслэл бүхий хүн чулуун хөргүүд нь он цагийн хувьд тодорхой бус тул бид ерөнхий дүрслэл бүхий хүн чулуун хөргүүд нь эрт үед үйлдэгдсэн байж магадлалтай хэмээн үзэж байна.

Сүүлийн үеийн судалгаагаар хүн чулуун

хөргүүдийн дүрслэл болон ур хийцээс хамаарч үүсэл хөгжил, зэрэг дэвийн асуудлыг ялгах боломж бүрдсэн бөгөөд бидний үзэж байгаагаар ерөнхий дүрслэл бүхий хүн чулуун хөргүүд нь өмнөх цаг үед, уран нарийн хийц дүрслэл бүхий хүн чулуун хөргүүдээс хожуу буюу Юань улсын үед үйлдэгдсэн байх боломжтой хэмээн үзэж байна (Амгаланбат 2020: 118). Үүний нэгэн баримт бол Сүхбаатар аймгийн Онгон сумын Таван толгой хэмээх газарт байрлах уран нарийн дүрслэлтэй хүн чулуун хөргүүд болон түүний орчимд байрлах судлаачдын үзсэнээр XIII-XIV зууны үед холбогдох булш оршуулгын дурсгал болно. Таван толгойн оршуулгын дурсгалт газар болон хүн чулуун хөрөгт тахилын байгууламж зэрэг дурсгал нь хаад язгууртанд зориулан үйлдсэн нь тодорхой хэдий ч яг чухам хэнд зориулан үйлдсэн хэмээх асуулт гарч ирдэг. Бид хүн чулуун хөргийн тархалт түүхэн сурвалж зэргээс үндэслэн Хонгирад аймгийн гаралтай, Юань улсын үеийн өндөр дээд хаад язгууртанд зориулан үйлдсэн байх боломжтой хэмээн үзэж байна.

Эртний түүхэн сурвалжийн мэдээллийг шүүн үзэхэд Монголын нууц товчоонд “...Амбагай хааны хоёр хатан Орбай, Сохотай нар өмнө тогтсон заншил ёсоор идээ цагааныхаа дээжийг ихсийн газарт өргөх...” хэмээн гардгаас үзэхэд бидний өвөг дээдэс эртнээс нааш хаад язгууртанд зориулан тусгай тахилга хийдэг байсан нь мэдэгддэг билээ. Гэтэл тухайн тахилын газарт хүн чулуун хөрөг босгон, үлдсэн талаар мэдээлэл байхгүй байна. Харин XIV зууны эхэн үед байгуулагдсан Юань улсын дээд нийслэл Шанд хотын орчимд илэрч олдсон хүн чулууд нь Дорнод Монголын хүн чулуудтай адил хийц загвартай байгаа нь он цагийг тодорхойлох баримт болж байна. Мөн Юань улсын сударт “...Хубилай хаан 1261 оны 4-р сард тэнгэр тахих үед Хуан Жү-гийн баруун хойд дүүрэгт хааны угсаанаас бусад ямар ч хүн оролцож болохгүй тахилга үйлдэв...” (Юань улсын судар, 138-р боть: 23) хэмээн өгүүлсэн нь хаад язгууртнууддаа зориулан тахилга тайллага үйлдэг байсан нь тодорхой байна.

Дүгнэлт

Монголчуудын XIII-XIV зууны үеийн түүхэнд холбогдох тахилга тайлгын түүхэн баримт, соёлын биет өв болон хадгалагдан ирсэн дурсгалын том жишээ бол Дорнод Монголын бүс нутгаар голлож тархсан хүн чулуун хөрөгт тахилын байгууламж юм. Тухайн хүн чулуун хөрөгт тахилын байгууламж нь XIII-XIV зууны үеийг төлөөлөх бие даасан дурсгал болохыг нэрт археологич Д.Баяр болон бусад судлаачдын ачаар дэлхий нийт хүлээн зөвшөөрч ном зохиолдоо оруулсаар ирсэн билээ. Харин бидний хувьд уг

дурсгалыг хайрлан хамгаалах, өмнөх судлаачдын судалгааг үргэлжлүүлэх, улам бүр нарийвчлан судлах нь нэн чухал билээ.

Энэхүү судалгааны хүрээнд бид судлаачдын болон өөрсдийн үзсэн ерөнхий дүрслэл бүхий 32 хүн чулуун хөргийн харьцуулсан судалгааг хийж тухайн үед холбогдох боломжтойг тодорхойлон XIII-XIV зууны үеийн хүн чулуун хөргийн тоог 123 болгон нэмж, шинэ хэрэглэгдэхүүнийг гаргаж ирсэн. Мөн хүн чулуун хөргийн тархалт дээр үндэслэн тэдгээрийг үлдээсэн хүмүүсийн угсаа гарвацийг тодорхойлох үүднээс Дорнод Монголд өргөн цар хүрээтэй тархсан хүрлийн үеийн дөрвөлжин булш, хүний нүүрний дүрслэл бүхий хадны зураг зэргийг түүхэн газар зүйн судалгаатай харьцуулан судалсны үр дүнд Хонгирад, Олхонуд, Татар зэрэг овог аймгийн түүхэн газар зүйтэй давхцаж байгааг тодруулсан юм.

Хүн чулуун хөргийн тахилын байгууламжийн малтлага судалгаанаас үзэхэд он цаг, хамрах үе харилцан адилгүй гарсан нь XIII зууны өмнөх үеэс эхлэн XVII зууны үеийг хүртэл тухайн хүн чулуун хөрөгт тахилын байгууламж дээр тахилга тасралтгүй хийж ирсэн нь тодорхой болсноос гадна хүн чулуун хөрөгт тахилын байгууламжууд нь ойролцоо бүс нутагт олон тоотой байгаа нь эртний тахилын газар болохыг батлан харуулж байна. Тухайн хүн чулуун хөрөгт тахилын байгууламжийн ойролцоо тахилын байгууламж эсвэл дагуул монгол булш байх магадлалтай дугуй чулуун дараас бүхий дурсгал цөөнгүй хэдэн газарт тааралддаг. Тухайн дурсгалуудыг малтан судалж байж үүрэг зориулалтыг мэдэж болох хэдий ч тэдгээрийг бид дагуул булш байх боломжтой хэмээн таамаглаж байна.

XIII-XIV зууны үеийн сурвалж бичгүүдийг шүүж үзэхэд тахилга тайллага үйлддэг байсан баримтууд тааралдаж байгаа хэдий ч хүн чулуун хөрөг босгож тахилга үйлдэж байсан тухай баримт Юань улсын сударт дурдагдаж эхэлсэн нь сонирхолтой байна. Эцэст нь тэмдэглэхэд хүн чулуун хөрөгт тахилын байгууламж нь Дорнод Монголын бүс нутагт төвлөн тархсан, эртний тахилын газар байсныг илтгэхээс гадна түүхэн газар зүйн байрлалын хувьд монгол угсаа гарвал бүхий Хонгирад, Олхонууд овог аймгийн бүс нутагтай давхцаж байгаа нь тухайн овог аймгийн хүмүүсийн үлдээсэн түүхэн дурсгал байх боломжтой хэмээх саналыг дэвшүүлэхэд хүргэж байна. Энэхүү овог аймаг нь Хамаг Монголоос эхлэн бүхэл цаг үеийн турш Дорнод Монголын тал нутагт өөрсдийн эзэмшил газарт амар тайван амьдарч ирснээс гадна Чингис хааны алтан урагтай ямагт холбоотой хүмүүс учир хаадын хөргийг тахилын газарт дүрслэн үлдээсэн байх боломжтой хэмээн үзэж байна. Мөн хүн чулуун хөргүүдийн дүрслэлийн хувьд ерөнхий дүрслэл бүхий хүн чулуун хөргүүд нь XIII зуунаас өмнөх үед, харин

уран нарийн дүрслэл бүхий хүн чулуун хөргүүд нь XIII-XIV зууны үед холбогдох боломжтой байна. Бид энэхүү судалгааг өмнөх судлаачдын XIII-XIV зууны үед хамааруулан үзсэн хүн чулуудын он цагийг ямар нэгэн байдлаар өөрчилсөн хэрэг бус харин хүн чулуун хөргүүдийн угсаа гарвацийг нэхэн тодруулахаар зорьсон болохыг энд тэмдэглэх нь зүйтэй хэмээн үзэж байна.

Abstract

Some issues of the study of sacrificial structure with stone man of the 13th-14th century in Mongolia

Batdelger Amgalanbat and Tumur-Ochir Iderkhangai

In this article, we will describe about Stone man monuments during XIII-XIV centuries were newly found on the territory of Mongolia, do their integrated distribution and compare them to the geographical situation of ancient Mongolian tribes. In addition, we tried to put forward our own suggestions regarding the period and date of the depiction, design, sacrificial structures of stone man monuments using their archeological excavations and historical sources.

Keywords: Eastern Mongolia, stone man monument, sacrificial structure, distribution, archaeological excavation, historical sources, Period of coverage

Ном зүй

Анхсанаа, Г. (2015). Шинээр олдсон исэр суудалт чулуун хөрөг. Чингис хаан судлал. УБ: 158-161.

Анхсанаа, Г. (2016). Дорнод Монголоос шинээр олсон хүн чулуу. Монгол судлалын олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. УБ: 17-20.

Амараа, Д. (2021). Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын “Зүүн нүхт”-ээс шинээр илрүүлсэн хүн чулууд. Монголын археологи 2021. УБ: 90.

Амгаланбат, Б. (2018). Өвөр Монголын нутагт орших XIII-XIV зууны үеийн хүн чулуудын судалгааны ажлын тайлан. УБ.

Амгаланбат, Б. (2019). Монголын XIII-XIV зууны үеийн хүн чулуудын дүрслэл он цагийн зарим асуудал.// (Магистрын диплом) Удирдагч багш Т.Идэрхангай. МУИС-ийн УБС-ийн номын сан. УБ.

Амгаланбат, Б. (2020). Өвөр Монголын Өөртөө Засах Орны нутагт орших XIII-XIV зууны үеийн хүн чулуудын тухай. *Studia Archaeologica*. Tom. XXXIX, Fasc. 1-17: 118.

Амартүвшин, Ч., Батзориг, О. (2014). Монгол нутаг дахь хүн чулуун хөшөөний судалгааны асуудалд (Газарзүйн

мэдээллийн санд тулгуурласан дүн шинжилгээ). *Studia Archaeologica*. Tom. XXXIV, Fasc. 23: 283.

Амартүвшин, Ч., Батдалай, Б., Батзориг, О., Дашзэвэг, Б. (2020). Хадны зураг дахь хүний нүүрний баг ба түүнд холбогдох зарим дүрслэлийн тухай. *Journal of the archaeology History and Ethnography*. Vol. 16, (15): 7-38.

Баяр, Д. (2013). Монголын дундад зууны археологийн судалгаа. 1-боть. УБ.

Баяр, Д. (2002). Монголчуудын чулуун хөрөг. УБ.

Бира, Ш., Дашцэдэн, Т., Сумъяабаатар, Б., Төмөртоого, Д., Цэдэнсодном, Д., Цэдэв, Д., Чоймаа, Д. (2009). Монголын нууц товчоо. УБ.

Гэрэлбадрах, Ж. (2002). Монголын нутаг дэвсгэр, хил хязгаарын түүх (МЭӨ III-XIX зуун). УБ.

Идэрхангай, Т., Оргилбаяр, С., Амгаланбат, Б., Батчимэг, Б., Баянсан, Б., Хүслэн, Л., Намсрайжамц, А., Уянга, Х., Мөнхжин, М. (2022). Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймгийн нутагт явуулсан “Чулуун соёлын өв” төслийн судалгааны ажлын 2022 оны тайлан. УБ.

Идэрхангай, Т., Амгаланбат, Б. (2023). Өмнөговь, Дундговь, Дорноговь аймгийн нутагт хийсэн хайгуул судалгааны ажлын тайлан-2023. УБ.

Казакевич, В.А (1930). Намогильные статуй в Дариганге. Ленинград.

Лхүндэв, Г., Болорбат, Ц., Одсүрэн, Д. (2012). Сэрхийн далангийн нэгэн хүн чулуун хөргийн тухай. *Studia Archaeologica*. Tom. XXXII, Fasc. 18: 291-297.

Наваан, Д., Мөнхдэлгэр, Ж. (2006). Сүхбаатар аймгийн Онгон сумын Таван толгойн тавдугаар булш ба Монголын язгууртны булш судлах асуудал. *Mongolian Journal of Anthropology, Archaeology and Ethnology*. Vol. 2(254): 10-28.

Монголын Улсын түүх. (2003). Монгол улсын түүх. Дэд боть (XII-XIV зууны үе). УБ.

Монголын үеийн хүн чулуу. (2016). Монголын археологийн өв. V боть. Монголын үеийн чулуун хөрөг (XIII-XIV зуун). Эрхлэн хэвлүүлсэн: Ч.Амартүвшин, Б.Бадам-Оюу. УБ.

Өлзийбаяр, С., Батсүрэн, Б., Очир, Б., Уртнасан, Э. (2019). Хүннүгийн дараах нүүдэлчид 2018 хээрийн судалгааны урьдчилсан үр дүн. Монголын археологи 2018. УБ: 227-228.

Рашид-ад-Дин. (2002). “Судрын чуулган”. Нэгдүгээр боть, УБ.

Сэр-Оджав, Н. (1970). Эртний түрэгүүд. УБ.

Соёлын Өвийн Үндэсний Төв. (2015). Соёлын Өвийн Үндэсний Төвийн үл хөдлөх дурсгалын улсын нэгдсэн тооллогын тайлан. тооллого Хэнтий аймагт ажилласан тайлан. УБ.

Төрбат, Ц., Батсүх, Д., Баярхүү, Н. (2017). Таван толгойн Монгол язгуртны булшнууд. Актуальные вопросы археологии и этнологии Центральной Азии. (Материалы II международной научной конференций, г. Улан-Удэ, 4-6 декабря 2017 г.), БНЦ СО РАН, 218-226.

Төрбат, Ц., Энхбаяр, Г., Амгаланбаатар, Б. (2022). Онгоны Таван толгойн 2022 оны археологийн малтлага судалгааны товч үр дүн. Монголын археологи-2022. УБ: 220-223.

Цэрэнбямба, Г. (2013). Нэгэн чулуун хөргийн тухай өгүүлэх нь. *Nomadic heritag studies museum national mongoli*. Tom. XV, Fasc.12: 84-87.

Хүслэн, Л. (2023). Монголын зүүн бүсийн зүүн бүсийн дөрвөлжин булшны судалгаа.// (Магистрын диплом) Удирдагч багш Т.Идэрхангай. МУИС-ийн УБС-ийн номын сан. УБ.

Чулуун, С., Ишцэрэн, Л., Эрдэнэ, Б., Амарболд, Э. (2018). Хүүхэн хонгор уулын хүн чулуун хөшөөний авран хамгаалах судалгааны товч үр дүн. Монголын археологи – 2017.

Бямбабадорж, Б., Очирбат, С., Цэнгүүн, Г. (2021). “Таван толгой 2021” хээрийн шинжилгээний ангийн товч үр дүн. Монголын археологи-2021. УБ: 97.


Эрдэнэбаатар, Д., Чулуун, С. (2011). Төв Халхын нутгаар хийсэн архео-этнологийн судалгаа. *Nomadic heritage studies*. Tom. XI, Fasc.19: 227-233.

Юань улсын судар, Сүн Лян /Мин/, Жүн Хуа Шү ЖҮ, 188-р боть: 58.


Юань улсын судар, Сүн Лян /Мин/, Жүн Хуа Шү ЖҮ, 138-р боть: 23.

Received: Oct. 22, 2024; Revised: Nov. 24, 2024; Accepted: Dec. 16, 2024






Зураг 1. Монгол нутаг дахь XIII-XIV зууны үед хамаарах үеийн хүн чулуун хөргийн тархалт




Зураг 2. Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт нэмэлтээр бүртгэсэн хүн чулуун хөргийн тархалт




Зураг 3. Дорноговь аймгийн Иххэт сумын нутагт байрлах шинээр бүртгэгсэн хүн чулуун хөргийн тархалт




Зураг 4. Монголын XIII-XIV зууны үеийн хүн чулуун хөрөгт тахилын байгууламж болон Түрэгийн үеийн тахилын онгоны гадаад зохион байгуулалтын харьцуулалт




Зураг 5. Монголын XIII-XIV зууны үеийн хүн чулуун хөргийн тархалтыг бүс нутгаар хуваасан байдал



Зураг 6. Сүхбаатар аймгийн нутаг дахь хүн чулуун хөргүүдийн төв тархалт



Зураг 7. Монголын дөрвөлжин булшны тархалт (Л.Хүслэнгийнхээр)



Зураг 8. Хүний нүүрний дүрслэл бүхий хадны зургийн тархалт (Ч.Амартүвшин нарынхаар)



Зураг 9. Хамаг Монголын овог аймгийн хилийн зураг (© Ж.Ганболд, Т.Мөнхцэцэг)